

ӨМНӨХ ҮГ

Эрхэм уншигч Та бүхэндээ,

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Стратеги судалгааны хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Стратегийн судалгаа” сэтгүүлийн 100 дахь дугаар уншигчдын гарт хүрч буй энэ түүхэн мөчид эрдэмтэн судлаачид, төрийн бодлого боловсруулагчид, хамтран ажиллагч байгууллага, сэтгүүлийн үе үеийн редакцын зөвлөл, зохиогч болон үнэнч уншигч Та бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

“Стратегийн судалгаа” сэтгүүл нь өнгөрсөн хугацаанд Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, гадаад бодлого, геополитик, бүс нутгийн харилцаа, батлан хамгаалах бодлого, эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчин, мэдээлэл, технологийн аюулгүй байдал зэрэг өргөн хүрээний асуудлаар эрдэм шинжилгээний болон бодлогын хэлэлцүүлгийн чухал индэр болсоор ирсэн билээ.

Сэтгүүлийн 100 дахь дугаарын онцлог нь Стратеги судалгааны хүрээлэнгийн хөгжилд өөрсдийн оюун мэдлэг, хөдөлмөр бүтээлээр хувь нэмрээ оруулж ирсэн үе үеийн удирдлага, судлаач нар болон аюулгүй байдал, стратегийн судалгааны салбарын нэр хүндтэй эрдэмтэн, шинжээчид бүтээлээ нийтлүүлсэн явдал юм. Иймээс энэхүү түүхэн тусгай дугаарт бүтээлээ ирүүлж, эрдэм мэдлэг, судалгааны туршлага, үнэт санаа, санал, дүгнэлтээ хуваалцсан зохиогчдодоо гүн талархал илэрхийлье.

Өнгөрснийг бүтээлцсэн, өнөөдрийг судлан шинжилж буй, ирээдүйг тодорхойлох шинэ үеийн судлаачдыг нэгэн үзэл санаа, үнэт зүйл, зорилгын хүрээнд холбож буй нь 100 дахь дугаарын утга учир юм.

Монгол Улсын аюулгүй байдал, төр, нийгэм, шинжлэх ухааны салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж ирсэн судлаачид, эрдэмтэн багш нар, хамтран ажиллагч байгууллагууд, уншигч Та бүхэндээ дахин талархал илэрхийлье.

Үндэсний эрх ашиг, стратегийн сэтгэлгээ, эрдэм мэдлэгийн үнэ цэн өнө мөнхөд бат оршиж, Монгол Улсын хөгжил дэвшлийн төлөөх оюуны эрэл хайгуул улам бүр өргөжин тэлэх болтугай.

**СТРАТЕГИ СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ,
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР О.МАШБАТ**